



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1101

Дуурлиг

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цэцэрлэгийн 2024 оны төсөвт хуваарилагдсан хоолны зардлаар Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал бэлтгэн нийлүүлэх ажлын гүйцэтгэлийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны ахлагч – С.Оюунтуяа \багш\

Нарийн бичиг – Э.Ариунжаргал \багш\

Гишүүн - М.Отгонжаргал \Нийгмийн ажилтан\

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу ил тод, шударга зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны ахлагч /С.Оюунтуяа/-д үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ

Г.АЗЖАРГАЛ

